



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА АРХАНГАЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

*Аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний
төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан*

**ХУУЛЬ, ТОГТ ООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭНД ТАВИХ ХЯНАЛТ СУЛ БАЙГААГААС
ОЙЖУУЛАЛТ, ОЙН ЦЭВЭРЛЭГЭЭНД ХУВААРИЛСАН ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН 78.8
ХУВИЙГ ҮР АШИГГҮЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА.**



АУДИТЫН НЭР: ОЙЖУУЛАЛТ, ОЙН ЦЭВЭРЛЭГЭЭНД ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН ҮР ДҮН

АГУУЛГА

	Товчилсон үгийн жагсаалт.....	2
Тайланг бэлтгэсэн:	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....	3
Архангай аймгийн Аудитын газар	БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС ОЙГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ, ҮРЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫГ ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН ХЭМЖЭЭГЭЭР ТӨЛӨВЛӨӨГҮЙ, БАТЛАГДСАН ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТЫН БУС ЗҮЙЛД, ҮР АШИГГҮЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА.	
Тэргүүлэх аудитор	Ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс зарцуулах хөрөнгийг хууль тогтоомжид заасан хэмжээгээр тооцож төлөвлөөгүй байна.....	6
Д. Уламбаяр	Аймгийн ойн менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт ойжуулалт, БСУТА гүйцэтгүүлсэн байна.	7
Аудитын менежер	Ойжуулалт, БСУТА, ойн цэвэрлэгээ хийх гүйцэтгэгчийг ТБОНӨХБАҮХТХууль, бусад хууль тогтоомжийн дагуу сонгосон байна.	8
Т.Байгалмаа	Хот суурин газрыг цэцэрлэгжүүлэх, ногоон байгууламж бий болгох зардлыг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.	9
Ахлах аудитор	Ойжуулалтын арга хэмжээнд төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр ашиг муу байна.	11
Д. Нэргүйбаатар	БҮЛЭГ 2. ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДЫН ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ, ЯЛАНГУЯА ОЙН ЭРХ БҮХИЙ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУД ГЭРЭЭГЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГЭЭ БҮРЭН ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.	
Шинжээч	Ойг нөхөн сэргээх, үржүүлэх талаар аймгийн БОАЖГ нь хуулиар хүлээсэн зарим үүргээ хэрэгжүүлээгүй байна.	14
Х. Алтанчимэг	Ойн нөхөрлөл, мэргэжлийн байгууллагууд хууль, тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй байна.	14
2016 оны 11 дүгээр сар	Бүлэг 3. ОЙН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАЖ ШАЛГААГҮЙ, ҮР НӨЛӨӨГ ТООЦООГҮЙ БАЙНА.	
Уг тайланг УАГ-ын Веб сайт-аас үзнэ ҮҮ.	Аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг батлуулаагүй байна.	15
www.audit.mn	Ой бүхий сумын ойн менежментийн төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулаагүй байна.	15
<i>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70332860 дугаарын утас, 70333141 дугаарын факсаар харилцана уу</i>	Аймаг, сумын ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж, хэрэгжилтийн үр нөлөөг тооцоогүй байна.	15
ХАЯГ:	Дүгнэлт	17
<i>Аймгийн ЗДТГ-ын байрны 3-р давхар 311 тоот өрөө</i>	Зөвлөмж	18
	Холбогдох байгууллагын санал	20
	Хавсралтууд	

Товчилсон үгийн жагсаалт

ААГ	АРХАНГАЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР
ҮАГ	ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ГА	ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ
ИТХ	ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ
УИХ	УЛСЫН ИХ ХУРАЛ
БСУТА	БАЙГАЛИЙН СЭРГЭН УРГАЛТАНД ТУСЛАХ АЖИЛ
БНАТТХ	БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ
ТБОНӨХБАҮХАТХ	ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬ
ЗДТГ	ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХАА	ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА
БОАЖГ	БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
ХНБЦГХЗ	ХАНГАЙН НУРУУНЫ БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГАА
БОАЖГ	БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
МХГ	МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
БОАЖС	БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД
БОНХС	БАЙГАЛЬ ОРЧИН НОГООН ХӨГЖЛИЙН САЙД

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын нэр	Ойжуулалт, ойн цэвэрлэгээнд зарцуулсан хөрөнгийн үр дүнд хийх гүйцэтгэлийн аудит
Аудитын код	ААГ-/2016/02-ГА
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд Аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.
Аудитын зорилт	Ойжуулалт, ойн цэвэрлэгээнд зарцуулсан хөрөнгийн үр дүнг шалгаж дүгнэлт гаргах, зөвлөмж боловсруулан холбогдох албан тушаалтанд танилцуулан улмаар орон нутгийн удирдлагад бодит мэдээлэл өгөх, шийдвэр гаргах түвшинд туслалцаа үзүүлэхэд аудитын зорилт оршлоо. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв.Үүнд: - Ойжуулалт, ойн цэвэрлэгээнд зарцуулах хөрөнгийг хууль, тогтоомжийн дагуу үнэн зөв төлөвлөж, үр ашигтай захиран зарцуулсан эсэх - Орон нутгийн засаг захиргааны болон ойн асуудал хариуцсан төрийн байгууллага, эрх бүхий ойн мэргэжлийн байгууллагууд түүнчлэн иргэн, хуулийн этгээд хуулиар хүлээсэн үүргээ үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх - Ойн менежментийн төлөвлөгөөг оновчтой боловсруулж, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх
Дэд зорилт	
Хамрах хүрээ	Аудитаар ойжуулалт, ойн цэвэрлэгээнд зориулж улс, орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрээс олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүнг санхүүгийн баримт материал, тайлан, ойжуулсан, цэвэрлэсэн талбайг хүлээн авсан баримт, материал, гүйцэтгэсэн ажлыг хамруулж шалгалаа. Ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөл, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр дүнг санамсаргүй түүврийн аргаар сонгож, тэдний ирүүлсэн тайлан, байгуулсан гэрээ, гүйцэтгэсэн ажлыг хамруулан шалгалаа. Мөн ойжуулалт, ойн цэвэрлэгээтэй холбоотой Монгол Улсын Их хурал, Засгийн газар, БОНХЯам, орон нутгийн засаг захиргааны байгууллагын гаргасан шийдвэрүүд, аймгийн Ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт зэргийг аймгийн эрх бүхий байгууллага болон холбогдох байгууллагын хүрээнд хамруулан шалгав.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан холбогдох иргэн, хуулийн этгээд, төрийн захиргааны байгууллагын албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, баримт бичгийг судлах, ойжуулсан, ойн цэвэрлэгээ хийсэн талбайг газар дээр очиж шалгах зэргээр асуудлын шинжилгээний тохирох аргазүйг ашиглав. Аудитын явцад цуглуулсан баримт материалыг шинжлэхдээ нөхцөл байдлыг хууль, тогтоомжийн үндсэн үзүүлэлттэй харьцуулах, зэрэгцүүлэх, мэдээлэл, нотлох баримтыг бүлэглэх, нэгтгэн дүгнэх, цуглуулсан судалгаа, шинжилгээний баримт материалд дүн шинжилгээ хийх зэрэг аргуудыг ашиглан аудитын хөтөлбөр горимын дагуу шаардлагатай нотлох зүйлсийг цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлсийг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

- ✓ Ойн тухай тухай хууль
- ✓ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
- ✓ “Ойн цэвэрлэгээ хөтөлбөр” МУЗГ-ын 2014 оны 30-р тогтоол
- ✓ Ойжуулалт, ойн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам”
- ✓ Архангай аймгийн “Ойн менежментийн төлөвлөгөө”
- ✓ Ойд цэвэрлэгээ арчилгаа хийх журам
- ✓ Ойгоос мод бэлтгэх журам
- ✓ Дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрхийн актууд
- ✓ Архангай аймгийн ИТХ-ын тогтоолууд

Хүндрэл бэрхшээл, бусад нөхцөл байдлын талаарх тайлбар

Аудитын явцад ойжуулалт хийсэн гүйцэтгэгч нар ойжуулсан газрын хаяг, тэмдэгжүүлэлтийг бүрэн хийгээгүйгээс зарим ойжуулсан талбайг шалгах, тооллого хийхэд хүндрэл бэрхшээлтэй байлаа.

Гүйцэтгэлийн аудитын багийн гишүүн зайлшгүй шаардлагаар өөр ажилд хуваарилагдсаны улмаас аудитын төлөвлөгөө хөтөлбөрт туссан “аймаг, сумын ИТХ, Засаг даргын эрх үүргийн хэрэгжилт”-ийг шалгах ажлыг гүйцэтгээгүй болно. Иймд дээрх асуудлыг аудитын тайлан тусгаагүй.

Оршил

Архангай аймаг нь 5531382 га талбай нутаг дэвсгэртэй. Үүний 1008613 га талбай нь ойн сан юм.

“Архангай аймгийн ойн санд 2008 онд хийсэн ойн зохион байгуулалтын тайлангаар 1996 оныхоос ойн сан 156252 га, үүнээс ойгоор бүрхэгдсэн талбай 93717 га талбайгаар буурсан байна.”¹

Түүнчлэн аудитад хамрагдсан 3 жилийн /2014-2016 он/ хугацаанд ойн сангаас нийт 297806.5 шоо метр мод бэлтгэж ашиглажээ. Өөрөөр хэлбэл ойн сан энэ хэмжээгээр буурсан гэсэн үг.

Ойгоос авч ашигласан нийт модны 31095.4 шоо метр нь хэрэглээний мод байх бөгөөд түүний 100 шоо метр тутамд 3 га талбайд ААНБ-ууд өөрийн хөрөнгөөр ойжуулалт хийх ёстой. Энэ хэмжээгээр тооцвол 2014-2016 онд зөвхөн ААНБ-ын өөрийн хөрөнгөөр Архангай аймагт нийт 932.6 га талбайг ойжуулж улсын ойн санд хүлээлгэн өгсөн байх ёстой.

Гэтэл энэ 3 жилийн хугацаанд нийт 554.5 га талбайд ойжуулах ажил, үүнээс 16 га талбайг ААНБ-ын өөрийн хөрөнгөөр ойжуулсан мэдээтэй байх бөгөөд ойжуулсан нэг ч га талбайг улсын ойн санд хүлээлгэн өгөөгүй байна. Ойг цэвэрлэх үйл ажиллагаанд 2014-2016 онд төсвөөс хөрөнгө зарцуулаагүй байна. Он тус бүрээр авч үзвэл дараах байдалтай байна.

2014 он

Аймгийн ойн сангаас 2014 онд 98961 м³ мод бэлтгэж ашиглахаар төлөвлөж аймгийн ИТХ-ын 2013 оны 12 дугаар тогтоолоор сум тус бүрээр дээд хэмжээг тогтоон баталсан бөгөөд гүйцэтгэлээр 86014.1 м³ мод бэлтгэсний 9139.4 м³ нь хэрэглээний мод байна.

Энэ онд өөрийн хөрөнгөөр 3 га, улсын төсвийн 69.3 сая төгрөгөөр 100 га, орон нутгийн төсвийн 39.7 сая төгрөгийн хөрөнгөөр 57.5 гад ойжуулалт, орон нутгийн төсвийн 22.0 сая төгрөгийн хөрөнгөөр 11 гад ойн зурвас байгуулах ажил гүйцэтгэсэн байна.

2015 он

2015 онд ойн сангаас 141837.5 м³ мод бэлтгэхээр төлөвлөж аймгийн ИТХ-ын 2014 оны 10-р тогтоолоор сум тус бүрийн дээд хэмжээг тогтоон баталсан бөгөөд гүйцэтгэлээр 92214 м³ мод бэлтгэсний 9310 м³ нь хэрэглээний мод байна. Мөн онд өөрийн хөрөнгөөр 6 га, улсын төсвийн 55.4 сая төгрөгөөр 80 га, орон нутгийн төсвийн 33.5 сая төгрөгөөр 50 га, нийт 130 га талбайд ойжуулалт, орон нутгийн төсвийн 9.9 сая төгрөгөөр 50 га талбайд БСУА, орон нутгийн төсвийн 50.0 сая төгрөгөөр Эрдэнэмандал суманд ногоон байгууламж нэмэгдүүлэх ажил гүйцэтгэсэн.

2016 он

Аймгийн ИТХ-ын 2015 оны 10 дугаар тогтоолоор 2016 онд нийт 105602.4 м³ мод бэлтгэхээр төлөвлөж, сум тус бүрээр хэмжээг баталсан, одоогоор мод бэлтгэлийн гүйцэтгэлийн мэдээ гараагүй байна. Энэ онд өөрийн хөрөнгөөр 7 га, улсын төсвийн 26.6 сая төгрөгөөр 40 га, орон нутгийн төсвийн 32.3 сая төгрөгөөр 50 га талбайд ойжуулалт, орон нутгийн төсвийн 19.9 сая төгрөгөөр 100 гад БСУТА, Цэцэрлэг сумын төвд ногоон байгууламжийн хайсыг 44.4 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн байна.

¹ БОАЖС-ын 2011 оны А-156 тушаалаар баталсан “Архангай

БҮЛЭГ 1

Орон нутгийн төсвөөс ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагаанд зарцуулах зардлыг хууль тогтоомжид заасан хэмжээгээр төлөвлөөгүй, батлагдсан зардлыг зориулалтын бус зүйлд, үр ашиггүй зарцуулсан байна.

- 1.1. Ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс зарцуулах хөрөнгийг хууль тогтоомжид заасан хэмжээгээр тооцож төлөвлөөгүй байна.

“Ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэхэд улсын төсвөөс зарцуулах хөрөнгийн хэмжээ нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлд зааснаас багагүй байна”²

“Ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагаанд Ойн нөөц ашигласан төлбөрийн нийт орлогын 85 хувиас багагүй хэмжээтэй тэнцэх хөрөнгийг зарцуулах”³

“Аймаг, нийслэлийн Засаг дарга нь орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, ойжуулалт, ойн арга хэмжээний ажлыг Байгаль орчны төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн ажлын хэмжээтэй уялдуулан Иргэдийн төлөөлөгчдийн хурлаараа 12 дугаар сарын 05-ны дотор батлуулна”⁴

Аймгийн ИТХ-аар жил бүр байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хэмжээг батлуулж ирсэн бөгөөд уг хөрөнгөнөөс ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагаанд зарцуулах зардлын хэмжээг, жил бүрийн ойн нөөц ашигласны орлогын төлөвлөгөөний дүнгээс хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож харьцуулан үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 1.

Үзүүлэлт	2014 он	2015 он	2016 он
Ойн нөөц ашигласны орлогын төлөвлөгөөний мөнгөн дүн /мян.төг/	242000*	496011.7**	383932***
“Ой хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэхтэй холбоотой зардал”⁵ /мян.төг/	117500	136750	215150
Нийт орлогын төлөвлөгөөний дүнд зардлын эзлэх хувь	48.6	27.6	56.0
Ой хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэхтэй холбоотой зардлыг хуульд заасны дагуу орлогын 85 хувиар тооцсон мөнгөн дүн /мян.төг/	205700.00	421609.95	326342.2
Зөрүү буюу дутуу төлөвлөсөн дүн /мян.төг/	-88200.00	-284859.95	111192.20
Зөрүү дутуу төлөвлөсөн хувь	36.4	57.4	29.0

*аймгийн ИТХ-ын 2014 оны 12 сарын 23 өдрийн 05-р тогтоолоор баталсан хэмжээ

** аймгийн ИТХ-ын 2015 оны 12 сарын 03 өдрийн 06 тогтоолоор баталсан хэмжээ

*** аймгийн ИТХ-ын 2016 оны 06 сарын 02 өдрийн 06 тогтоолоор баталсан хэмжээ

Энэ хүснэгтээс харахад 2014-2016 онд ойг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд орон нутагт ойн нөөц ашигласны төлбөрийн төвлөрүүлэх орлогоос зарцуулах зардлын хувь хэмжээг БНАТТХ-ийн 18.1-д заасан доод хувь хэмжээнээс жил бүр доогуур буюу 29.0-57.4 хувиар бага, мөнгөн дүнг 88.2-284.9 сая төгрөгөөр дутуу төлөвлөж баталж иржээ. Энэ нь Ойн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсэг, БНАТТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

² Ойн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсэг

³ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар 18.1 дэх хэсэг

ААГ-/2016/02-ГА

⁴ БОНХСайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны А-96/71 тушаалаар баталсан журам

⁵ Аймгийн ИТХ-аар баталсан “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөгөөнөөс ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагаатай холбоотой зардлыг түүвэрлэсэн дүн

1.2.1. Аймгийн ойн менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт ойжуулалт, БСУТА гүйцэтгүүлсэн байна.

Архангай аймагт 2014-2016 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлсэн ойжуулалт, БСУТА-г аймгийн ойн менежментийн төлөвлөгөөтэй харьцуулан үзэхэд дараах байдалтай байна. Дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс үзнэ үү.

Хүснэгт 2. Архангай аймагт 2014-2016 онд ойжуулсан талбай

Арга хэмжээ	Талбайн хэмжээ /га/			НИЙТ
	2014 он	2015 он	2016 он	
Ойжуулалт:				
УТХО-аар	100.0	80	40	220.0
ОНТХО-аар	57.5	50	50	157.5
БСУТА	0	50	100	150.0
Ойн зурвас байгуулах	11	0	0	11.0
Бүгд	168.5	180.0	190.0	538.5

Үүнээс:

Аймгийн Ойн менежмент төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт хийсэн ойжуулалтын судалгаа /Хүснэгт 3./

“Аймаг, нийслэлийн Засаг дарга нь тухайн нутаг дэвсгэртээ улсын захиалгаар болон аймаг, сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний төлөвлөгөөний төсөл зохиож, Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тухайн жилийн 02 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ”⁶

“Ойн менежментийн төлөвлөгөө гэж тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх, эсхүл эзэмшлийн ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд чиглэгдсэн ойн аж ахуйн арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг цогц байдлаар тодорхой үе шаттайгаар тусгаж төлөвлөсөн баримт бичиг”⁷

НЭР		гүйцэтгэсэн АЖИЛ	ХЭМЖЭЭ ЭС ГА/	гүйцэтгэсэн он
1	Хайрхан даржаа	ойжуулалт	13.5	2014
2	Булган уулын зүүн суга	ойжуулалт	10	2014
3	Цэнхэр Янгиртай хясаа	ойн зурвас	11	2014
4	Өлзийт байширын Шандат	ойжуулалт	25	2015
5	Цэнхэрийн Хэц бэлчир	ойжуулалт	15	2016
6	Эрдэнэмандал Тээлийн ӨЛ	БСУТА	50	2016
НИЙТ			124.5	
УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР				
1	Тариат Шанаатын булаг	ойжуулалт	50	2014
2	Тариат Шанаатын мандал	ойжуулалт	50	2014
3	Хайрхан Адуун зураа, Хэцүүгийн овоо	ойжуулалт	40	2015
4	Хотонт Модот толгой	ойжуулалт	20	2016
НИЙТ			160.0	

Дээрх хүснэгтүүдээс харахад улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ойжуулалтын дийлэнх буюу 72.7 хувь нь аймгийн Ойн менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт хийгдсэн байна. Түүнчлэн орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ойжуулалт, БСУТА, ойн зурвасын 39.1 хувь нь ойн менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт хийгдсэн байгаа нь БОНХЯС-ын тушаал⁸-аар баталсан аймгийн ойн менежмент төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, өөрөөр хэлбэл хэн нэгний эрх ашигт нийцүүлэн дур мэдэн газраа сонгож байна гэж үзэхэд хүргэж байна.

⁶ БОНХСайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны А-96/71 тушаалаар баталсан журам

⁷ Ойн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалт

⁸ БОАЖСайдын 2011 оны 05 сарын 12-ны өдрийн А-156 тушаалаар баталсан Архангай аймгийн ойн менежментийн төлөвлөгөө /2011-2015/

1.2.2. **Ойжуулалт, БСУТА, ойн цэвэрлэгээ хийх гүйцэтгэгчийг ТБОНӨХБАҮХТХууль, бусад хууль тогтоомжийн дагуу үнэн зөв сонгосон байна.**

“Аймгийн Байгаль орчны газар нь ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх зориулалтаар төсвөөс хуваарилсан хөрөнгийг гэрээ байгуулан гүйцэтгэгчид олгож, түүний зарцуулалтанд хяналт тавьж, гүйцэтгэлийг тайлагнах”⁹

“Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах өмчлүүлэх журам”¹⁰-ын 3.2.1-д “**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалт явуулж ... гэрээ байгуулан ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг гүйцэтгүүлэх, хүлээж авах**”

Мөн журмын 3.2.7-д “урьд онуудад ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагатай орон нутгийн болон улсын захиалга, даалгавраар дахин ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлын гэрээ хийхгүй байх”

Архангай аймагт 2014-2016 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ойжуулалт, БСУТА-ын гүйцэтгэгчийг сонгох ажлыг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан үнэлгээний хороо, Засаг даргын дэргэдэх Худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж хэрэгжүүлсэн байна. Дэлгэрэнгүйг Хавсралт 2-оос үзнэ үү.

Хүснэгт 4. Ойжуулалтын ажлын ХАА-ны судалгаа

Тендер шалгаруулалтын		Төсөвт өртөг мян.төг	ХАА-ны арга	Захирамжын огноо, дугаар	Гэрээний дүн мян. төг
Нэр	Дугаар				
орон нутгийн төсвийн хөрөнгөөр 57.5 га талбайд ойжуулалт хийх ажил	АРХААА 61/2014	40000	ХА	,2014.06.10 а/324	39717.5
Улсын төсвийн хөрөнгөөр 100 гад ойжуулалт хийх ажил	АРХААА /29/2014	70000	ХА	2014.04.16 а/194	69300
Орон нутгийн төсвийн хөрөнгөөр ойжуулалт 50 га, БСУТА 50 га-д ойжуулалт хийх ажил	АРХААА-14/2015	44800	ХА	2015.05.22 а/220	43429.3
Улсын төсвийн хөрөнгөөр 80 га талбайд ойжуулалт хийх ажил	АРХААА /11/2015	55600	ХА	Шаардлага хангасан тендер ирээгүй	55387.00
Орон нутгийн төсвийн хөрөнгөөр ойжуулалт 50 га, БСУТА 100 га-д ойжуулалт хийх ажил	АРХААА-ХА/02/2016,	54750	ХА	2016.04.11 а/176, 2016.04.12 а/179	52200
Улсын төсвийн хөрөнгөөр 40 га талбайд ойжуулалт хийх ажил	АРХААА/ХА/01/2016	27800	ХА	2016.03.21 а/114	26550

Үнэлгээний хороо нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасныг үндэслэн МУЗГ-ын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан босго үнийг баримталж ХАА-ны аргыг сонгосон байх бөгөөд ХАА-г хууль, журмын дагуу зохион байгуулж, Сангийн Сайдын 2012 оны 194 тушаалаар баталсан “Тендерийн үнэлгээний заавар”-ын дагуу үнэлгээ хийж зөвлөмж хүргүүлжээ. Эрх бүхий албан тушаалтан Үнэлгээний хорооны зөвлөмжийн дагуу хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах шийдвэр гаргаж ажилласан байна.

Гэвч үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд аймгийн БОАЖГ-ын ойн асуудал хариуцсан мэргэжилтэн болон төрийн бүс байгууллагын төлөөллийг оролцуулаагүй ТБОНӨХБАҮХАТХ-ийн 47.4-д заасныг мөрдөөгүй байв. Үүний улмаас журмын 3.2.7-д заасныг хэрэгжүүлээгүй байлаа.

Харин улсын тусгай хамгаалалттай газарт ойн цэвэрлэгээ хийх ажлын гүйцэтгэгчийг БОНХСайдын тушаалын дагуу ХНБЦГХЗахиргаа сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажилласан байна.

⁹ Ойн тухай хуулийн 17.3.10

¹⁰ БОНХСайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны А-96/71 тушаалаар баталсан журам

Байгаль Орчин Ногоон хөгжлийн Сайдын 2014 оны А-382 дугаар тушаалын 2-д “Улсын тусгай хамгаалалттай газрын зөвшөөрөгдсөн бүсэд ойн цэвэрлэгээний ажил хийх талбай тусгаарлалтын ажлыг ойн ангиар гүйцэтгүүлэн түүний үндсэн дээр ойн мэргэжлийн эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагуудын дүнд сонгон шалгаруулалт явуулж хэрэгжилтийг ханган ажиллахыг холбогдох тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны дарга нарт үүрэг болгосугай”

Хүснэгт 5. Тусгай хамгаалалттай газарт ойн цэвэрлэгээ хийхээр шалгарсан гүйцэтгэгч

Ойн цэвэрлэгээ хийх ойн сангийн нэр, хэсэглэлийн дугаар	бэлтгэх модны хэмжээ м3	Шалгарсан гүйцэтгэгчийн нэр	Сайдын тушаалын огноо, дугаар	Эрх олгосон даргын тушаалын огноо, дугаар
Цэнхэр сум 70-р хэсэглэл	379.245	Тэлээ таван хайрхан ЗБН	2014.01.06 А-06*	2014.10.13 №39
Цэнхэр сум 70-р хэсэглэл	312.36	Цэн тайга ХХК	2014.01.06 А-06	2014.10.13 №39
Цэнхэр сум 69-р хэсэглэл	337.41	Ар бүрд өгөөж ХХК	2014.01.06 А-06	2014.10.13 №39
Цэнхэр сум 69-р хэсэглэл	228.894	Харзны дэнж ХХК	2014.01.06 А-06	2014.10.13 №39
2014 оны дүн	1257.909			
Цэнхэр сум 51-р хэсэглэл	359.8	Тэлээ таван хайрхан ЗБН	2014.10.31 А-382**	2015.11.10 А/23
Цэнхэр сум 51-р хэсэглэл	318.5	Ар бүрд өгөөж ХХК	2014.10.31 А-382	2015.11.10 А/23
Цэнхэр сум 51-р хэсэглэл	378.1	Харзны дэнж ХХК	2014.10.31 А-382	2015.11.10 А/23
Цэнхэр сум 51-р хэсэглэл	318.5	Цэн тайга ХХК	2014.10.31 А-382	2015.11.10 А/23
Цэнхэр сум 51-р хэсэглэл	256.068	Ноёнхангайн хишиг ХХК	2014.10.31 А-382	2015.11.10 А/23
2015 оны дүн	1630.968			

*БОНХСайдын 2014 оны А-06 тушаалын 2 дахь заалт

**БОНХСайдын 2014 оны А-382 тушаалын 2 дахь заалт

1.3.1. **Хот суурин газрыг цэцэрлэгжүүлэх, ногоон байгууламж бий болгох зардлыг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.**

Аймгийн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлын хүрээнд ойжуулах, ойн арга хэмжээнд зарцуулахаар баталсан зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн байдлыг 2014-2016 оноор авч үзвэл дараах байдалтай байна. Дэлгэрэнгүйг Хавсралт 3-аас үзнэ үү.

Хүснэгт 6. Ойжуулах, ойн арга хэмжээний зардлын төлөвлөгөө ба гүйцэтгэл 2014-2016 он /мян.төг-өөр/

	2014 он		2015 он		2016 он*	
	төл	гүйц	төл	гүйц	төл	Гүйц
Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний нийт зардал	117500	102817.5	182150	175402.3	215150	80350

*2016 оны гүйцэтгэлийг эхний 6 сарын гүйцэтгэлээр авсан болно.

Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.4 дэх хэсэг: “сум өөрийн төсвөөр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”

58.4.8-д “сумын тохижилт, мод ургамал, цэцэрлэгжүүлэлт, явган зам, амралт болон хүүхдийн тоглоомын талбайг тохижуулах”

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6-д “Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх”

Дээрх батлагдсан зардлыг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг анхан шатны баримтаар тулган шалгасан бөгөөд 2015 оны зарцуулалтыг УАГ-ын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитын хүрээнд шалгаж дүнг уг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын явцад 2015 онд 50.0 сая төгрөгийг Эрдэнэмандал сумын Ёслол хүндэтгэлийн талбай байгуулах, 2016 онд 44.4 сая төгрөгийг Цэцэрлэг сумын төвийн ногоон байгууламжийн зөвхөн хайс, хамгаалалтыг хийх ажилд олгосон, энэхүү санхүүжилтээс сумын төвд ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт нэмэгдүүлэх ажил хийгээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг зөрчсөн байна.

Мод тарьж, цэцэрлэгжүүлэлт хийгээгүй байгаа нь



Зураг 1. Эрдэнэмандал сумын Ёслол хүндэтгэлийн талбай 2016.09.27

Түүнчлэн Төсвийн тухай хуулийн 58.4.8-д заасан сумын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “сумын төвийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт хийх” чиг үүргийг аймгийн төсвийн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар санхүүжүүлэхээр төлөвлөж, зарцуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.6.6-д заасныг зөрчиж байна.



Мод тарьж, цэцэрлэгжүүлэлт хийгээгүй байгаа нь

Зураг 2. Цэцэрлэг сумын ногоон байгууламжийн хайс 2016.09.26

Аймгийн БОАЖГ-т батлагдсан хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах зөрчлийг таслан зогсоож дээрх 2 суманд ногоон байгууламжинд мод тарьж цэцэрлэгжүүлэх ажлыг хийлгэж хүлээн авах хугацаатай албан шаардлагыг хүргүүлээд байна.

1.3.2. Ойжуулалтын арга хэмжээнд төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр ашиг муу байна.

Архангай аймагт 2014-2016 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ойжуулалтын арга хэмжээний зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл дараах байдалтай байна.

Хүснэгт 7. Төлөвлөгөө ба гүйцэтгэл 2014-2016 он

	2014 ОН			2015 ОН			2016 ОН		
	хэмжээ га	Төл	гүй	хэмжээ га	Төл	гүй	хэмжээ га	Төл	гүй
УТХО	100.0	70.0	69.3	80	55.6	43.4	40	27.8	13.9
ОНТХ	68.5	62.0	61.7	100	44.75	27.7	150	54.8	28.4
	168.5	132.0	131.0	180	100.35	71.1	190	82.6	42.3

Ойжуулалтын ажлын гүйцэтгэл, тарьцын ургалтын байдлыг аймгийн Тэргүүлэх аудиторын баталсан удирдамжийн дагуу ажлын 2 хэсэг гарч газар дээр нь үзэж жишиг талбай авч тоолж шалгахад ойжуулсан талбайг хашиж хамгаалаагүй, анхааруулах самбар, хаяг, тэмдэгжүүлэлт, 2 ба 3 дахь жилийн нөхөн тарилт, арчилгаа тордолгоог хийгээгүй нийтлэг зөрчил илэрлээ. Мөн зарим ойжуулсан талбайд тарьц огт ургаагүй, зарим газарт үр, тарьцын ургалт хангалтгүй, байгалийн өөрийн аясаар сэргэн ургаж буй газарт ойжуулалт хийсэн зэргээр төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 4-ээс үзнэ үү/ Тухайлбал:

2014 онд хийсэн ойжуулалтаас:

- Цэнхэр сумын Янгиртай Хясаанаас Хэвтээ толгой хүртэл 11 гад ойн зурвас байгуулах ажлыг Элэгтэй Хайрхан ХХК орон нутгийн төсвийн 22.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн боловч 0.1 га хашаа барьж, мод тарьснаас өөр зүйлгүй.
- Булган Уулын зүүн суганд 10 га талбайд орон нутгийн төсвийн 6.9 сая төгрөгөөр Дуут нөхөрлөлийн ойжуулсан талбайд тарьц огт ургаагүй.
- Тариат сумын Шанаатын мандалд улсын төсвийн 34.6 сая төгрөгөөр Олз мод ХХК-ний хийсэн ойжуулалтын тарьц огт ургаагүй.
- Тариат сумын Шанаатын Булаг хэмээх газар улсын төсвийн 34.7 сая төгрөгөөр Ойд Хангай ХХК-ний хийсэн ойжуулалтын тарьц огт ургаагүй.
- Хотонт сумын Ар жаргалантын 10 гад Цахир баян Уул ХХК-ний орон нутгийн төсвийн 6.9 сая төгрөгөөр ойжуулсан тарьцын 70 хувь ургаагүй.

2015 оны ойжуулалтаас:

- Хайрхан сумын Адуун зураа, Хэцүүгийн овоо гэх газар байгалийн аясаар сэргэн ургаж буй 40 гад 13.8 сая төгрөгөөр ойжуулалт хийсэн
- Өлзийт сумын Шандатын 25 гад 16.5 сая төгрөгөөр ойжуулсан тарьцын 60 хувь ургаагүй.
- Батцэнгэл сумын Овгор улааны 25 гад 17.0 сая төгрөгөөр ойжуулсан тарьцын 60 хувь нь ургаагүй.
- Цэцэрлэг сумын Эхний хавтгай, Эхний булагийн 40 гад 13.8 сая төгрөгөөр ойжуулсан тарьцын 47.7 хувь ургаагүй.


2016 оны ойжуулалтаас:

- Хотонт сумын Модот толгойд 10 гад 6.8 сая төгрөгөөр ойжуулсан тарьцын 90 хувь ургаагүй.
- Өндөр-улаан сумын Гарчинд 20 гад 6.4 сая төгрөгөөр ойжуулсан тарьцын 50 хувь ургаагүй.
- Эрдэнэмандал сумын Өлийн 50 гад 9.95 сая төгрөгөөр хийсэн БСУТА-ын үрийн цухуйлт 40 хувьтай байна.

Тарьц ургасан байгаа нь:



БСУТА-ын үр цухуйсан байдал:



Тарьц огт ургаагүй, ургалт шаардагдах хэмжээнд хүрээгүй ойжуулалтанд зарцуулсан хөрөнгийн хэмжээ /оноор/:

Хүснэгт 8.

Он	Зарцуулсан хөрөнгө /сая.төг/, хэмжээ /га/ Нийт		Шаардлага хангахгүй ойжуулалт		Нийт зардалд эзлэх хувь	Нийт ойжуулсан талбайд эзлэх хувь
	Сая.төг	Га	Сая.төг	Га	%	%
2014 он	131	168.5	104.4	131	79.7	77.7
2015 он	71.1	180	61.2	130	86.1	72.2
2016 он	39.4	190	24.7	90	62.7	47.3
Бүгд	241.5	538.5	190.3	351	78.8	65.2

Дээрх хүснэгтээс харахад 3 жилд нийт ойжуулсан талбайн 65.2 хувь, зарцуулсан нийт зардлын 78.8 хувь буюу 190.3 сая төгрөгийн ойжуулалтын тарьцын ургалт шаардагдах хэмжээнд хүрээгүй байгаа нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан гэж үзэхэд хүргэж байна.

Тарьц ургаагүй хатсан байгаа нь:



Тарьц ургаагүй хатсан байгаа нь : Ойн зурваст мод ургаагүй байна:



1.3.3. Ойн цэвэрлэгээнд төсвөөс хөрөнгө зарцуулаагүй, цэвэрлэгээний ажлын үр дүн муу байна.

“ойн цэвэрлэгээ” гэж ойн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн, хүчтэй салхи, их цасанд өртөн амьдрах чадваргүй болж үхжиж унасан хуурай мод, гишүү, мөчир, мод бэлтгэлийн талбайн үлдэгдлийг цэвэрлэх замаар ойг хамгаалах, ойн төлөв байдлыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг хэлнэ.¹¹

Архангай аймагт 2014-2015 онд нийт 1110 га талбайд ойн цэвэрлэгээ хийж 157163.6 м3 мод бэлтгэжээ. Гэвч ойн цэвэрлэгээнд зориулж төсвөөс хөрөнгө зарцуулаагүй байна. Ойн цэвэрлэгээ хийх талбайг сум дундын ойн ангиас ойн нөхөрлөл, мэргэжлийн байгууллагуудад талбай тусгаарлалт хийж өгөн, гэрээ байгуулан ажилладаг байна. Аудитын явцад Ихтамир суманд ойн цэвэрлэгээ хийж буй “Ар өгөөж” ББН, Жаргалант суманд ойн цэвэрлэгээ хийж буй “Арын сайхан хангайн арвижин дэлгэрэх баян зүрх хайрхан” ББН-ийн цэвэрлэгээний ажлын явцтай танилцлаа.



Жаргалант сум.
Булгийн хоолой
2016.09.25

Ойн цэвэрлэгээний явц удааширалтай, өмнөх онд гэрээлсэн талбайгаа бүрэн цэвэрлэж дуусаагүй. Түүнчлэн унанги, гишүү, мод бэлтгэлийн талбайн үлдэгдэл мөчрийг ойн цоорхойд овоолж орхисон байлаа. Энэ нь ойн цэвэрлэгээгээр бэлтгэсэн унанги, өмхөрсөн мод, гишүү, мөчрийг иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд түлшинд худалдан авч хэрэглэдэггүйтэй холбоотой, нөгөө талаас манай аймагт үүнийг ашиглан шахмал түлш, шахмал модон эдлэлийн бэлдэц хийх үйлдвэр байхгүйтэй холбоотой гэж ойн цэвэрлэгээ хийж буй гүйцэтгэгч нар тайлбарлаж байлаа.

Ойн цэвэрлэгээг бүрэн үр дүнтэй хийхгүй байгаагаас ойд хөнөөлт шавж тархах, голомт үүсэх, түймэр гарах нөхцлийг бүрдүүлж ойг нөхөн сэргээхэд хүндрэл учруулахаар байна.

Иймд орон нутгийн удирдлагын түвшинд ойн цэвэрлэгээг дэмжих бодлогын арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ингэснээр ойг хамгаалах, эрүүлжүүлэх, төлөв байдлыг сайжруулах экологийн төдийгүй нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой арга хэмжээ болох юм. Тухайлбал дараах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж болохоор байна. Үүнд:

- Унанги, гишүү, мөчир ашиглан шахмал түлш, шахмал модон бэлдэц хийх үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжих
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгодог ажил олгогчийг дэмжих, бизнес эрхлэгчдийг дэмжих зэрэг хөтөлбөрт энэ төрлийн үйлдвэрлэл эрхлэгчдийг тэргүүн ээлжинд хамруулах, нийтийг хамарсан ажлын санхүүжилтээр ойд цэвэрлэгээ хийх

¹¹ Ойн тухай хуулийн 3.1.15 заалт

БҮЛЭГ 2

Холбогдох байгууллагуудын хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт хангалтгүй, ялангуяа ойн эрх бүхий мэргэжлийн байгууллагууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

“Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага ой, хээрийн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн, түүнчлэн мод бэлтгэсэн талбайн ойг нөхөн сэргээх, үржүүлэх арга хэмжээг улсын захиалгаар улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, өөрийн хөрөнгө дотоод, гадаадын хандив тусламжаар гүйцэтгэнэ”¹²

2.1.1. Ойг нөхөн сэргээх, үржүүлэх талаар аймгийн БОАЖГ нь хуулиар хүлээсэн зарим үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Тухайлбал:

- Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.9-д заасныг хэрэгжүүлээгүй буюу ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөг батлаагүй, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаагүй.
- Урьд онуудад ойжуулалт, ойн арга хэмжээний ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн ойн мэргэжлийн байгууллагуудтай улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр ойжуулалтын ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулахгүй байх тухай “холбогдох журам”¹⁴-ын 3.2.7-д заасныг хэрэгжүүлээгүй.
- БОНХСайдын 2014 оны А-06 ба А-382 дугаар тушаалын 3-д заасан “ойгоос бэлтгэсэн хэрэглээний модны 100 шоометр тутамд өөрийн хөрөнгөөр 3 га талбайд ой тарьж ургуулах ажлыг холбогдох нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагаар хийлгэх арга хэмжээг ойн анги, сумын ЗДТГ, ХНБЦГХЗ, аймгийн МХГ-тай хамтран зохион байгуулах” ажлыг хэрэгжүүлээгүй байна.

2.1.2. Ойн нөхөрлөл, мэргэжлийн байгууллагууд хууль, тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй байна.

- Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагуудын ойг нөхөн сэргээх үүргийн талаар Ойн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт “огтолсон 1 модны оронд 10 буюу түүнээс дээш тарьц суулгацыг ойд тарьж ургуулж, улсын ойн санд хүлээлгэж өгнө”, БОНХСайдын 2014 оны А-06, А-382 дугаар тушаалын 3-д “ойгоос бэлтгэсэн хэрэглээний модны 100 шоометр тутамд өөрийн хөрөнгөөр 3 га талбайд ой тарьж ургуулах...” гэж тус тус заасан байна.

2014-2016 онд бэлтгэсэн хэрэглээний модны хэмжээ Хүснэгт 9.

Төрөл	2014	2015	2016*	Нийт
Үйлдвэрлэлийн огтлол	0	400	50	450
Арчилгааны огтлол	1387	110	1130	2627
Цэвэрлэгээний огтлол	7748.4	8800	8420	24968.4
Цэвэрлэгээний ажил	0	0	3050	3050
	9135.4	9310	12650	31095.4

Гэтэл 2014-2016 онд аж ахуйн нэгж, байгууллагууд өөрийн хөрөнгөөр 16 га талбайд 10.5 сая төгрөгийн ойжуулалт хийжээ. Үүнийг хууль, тогтоомжид заасан ойжуулах хэмжээтэй харьцуулбал дараах байдалтай байна.

Бэлтгэсэн мод м3	100 шоометр шилжүүлснээр	Өөрийн хөрөнгөөр ойжуулбал зохих талбай /га/	Өөрийн хөрөнгөөр ойжуулсан талбай /га/	Зөрүү буюу ойжуулаагүй талбай /га/
31095.4	310.95	932.9	16	916.9

Урьд онуудад ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагатай орон нутгийн болон улсын захиалга, даалгавраар дахин ойжуулалт, ойн арга хэмжээний ажлын гэрээ хийхгүй байх”¹³

¹² Ойн тухай хуулийн 30.1 дэх хэсэг

¹³ БОНХСайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны А-96/71 тушаалаар баталсан журам

¹⁴ БОНХСайд, Сангийн Сайдын 2013 оны 03 сарын 29-ний өдрийн А-96/71 тушаалаар баталсан журам

“Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах өмчлүүлэх журам”¹⁵-ын 4.7-д

“ойжуулалт, ойн зурвас төгөл байгуулах, ойг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэсэн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь ойжуулсан талбайгаа 3 жилийн хугацаанд арчлан ургуулах бөгөөд энэ үзүүлэлтийг дараагийн ойжуулалтын ажил гүйцэтгэх гэрээ байгуулахад нэг шалгуур үзүүлэлт болгоно”

Дэлгэрэнгүйг хавсралт 5-аас үзнэ үү.

Дээрх хүснэгтээс харвал сүүлийн 3 жилд өөрийн хөрөнгөөр ойжуулбал зохих талбайгаас 916.9 га буюу 98.3 хувийг хийгээгүй байгаа нь хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт хангалтгүй, аймгийн БОАЖГ, сум дундын ойн анги зэрэг байгууллагууд хуулийн хэрэгжилтийг хангуулдаггүй, салбарын сайдынхаа тушаалыг хэрэгжүүлдэггүй болох нь харагдаж байна. Үүнээс болж ойн сан 916.9 га буюу 1 га ойжуулах “зардлын норматив”¹⁶аар тооцвол 637.2 сая төгрөгөөр хохирчээ. Хэрэв бүрэн хэрэгжүүлсэн бол ийм хэмжээний ойжуулалт хийгдэж улсын ойн сан нэмэгдэх байлаа.

Хэдийгээр өөрийн хөрөнгөөр хийх ойжуулалт хангалтгүй байгаа ч улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр сүүлийн 3 жилд 538.5 га ойжуулалт хийсэн мэдээтэй байна. Энэ тухай өмнөх бүлэгт тусгасан болно. Сүүлийн 3 жилд төсвийн хөрөнгөөр хийсэн ойжуулалтын хэмжээг авч ашигласан хэрэглээний модны 100 м³ тутамд харьцуулбал дараах байдалтай байна.

Он	Бэлтгэсэн хэрэглээний мод /м ³ /	100 м ³	Хийсэн ойжуулалт /га/	100 м ³ -д ногдох ойжуулалт /га/
2014	9135.4	91.3	168.5	1.85
2015	9310	93.1	180	1.93
2016	12650	126.5	190	1.5
Дундаж	10363.3	103.7		

Дээрх хүснэгтээс харахад авч ашигласан хэрэглээний модны 100 м³ тутамд хийх ёстой 3 га талбайг төсвийн хөрөнгөөр ч ойжуулж чадахгүй байгааг харуулж байна. Цаашдаа энэ байдал үргэлжилсээр байвал магадгүй 10 жилийн дараа (дундажаар 103.7*3га*10 жил*98.3%) 3058.1 га талбайг ойжуулахгүй орхигдуулж улмаар ийм хэмжээний талбайн ойн нөөц багасах эрсдэл үүсч болзошгүй байна.

- Ойжуулах, ойн арга хэмжээг гүйцэтгэгч ойн мэргэжлийн байгууллагын эрх үүргийн талаар БОНХСайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны А-96/71 тушаалаар баталсан журмын 4.7-д тодорхой заасан байна. Түүнчлэн ойжуулалт, БСУТА, ойн зурвасын ажил хийлгэхээр гүйцэтгэгч нартай байгуулсан гэрээний тусгай нөхцлийн 32-д “Чанарын баталгаат хугацаа 3 жил байна”, тусгай нөхцлийн нэмэлтийн “ж”-д “ойжуулсан талбайг 3 жил арчилж ургуулах, шаардлагатай үед нөхөн тарилтыг хийнэ” гэж заасан байна.

Гэтэл 2014-2016 онд Архангай аймагт улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр ойжуулалт, БСУТА, ойн зурвас байгуулах ажил гүйцэтгэгч нар дээрх үүргийг хэрэгжүүлээгүй, үүний улмаас төсвийн 190.3 сая төгрөгийн ойжуулалт үр дүнгүй болсон зөрчил илэрсэн. Энэ тухай аудитын тайлангийн 1-р бүлгийн 1.3.2-д тодорхой тусгасантай танилцаж дэлгэрэнгүйг хавсралт 4-ээс үзнэ үү.

Аудитын явцад хууль, тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй 4 аж ахуйн, нэгж байгууллагыг төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан эсэхийг тогтоолгохоор хуулийн байгууллагад материалыг шилжүүлж, намрын болон 2 дахь жилийн нөхөн тарилт, арчилгаа, хамгаалалтыг хийгээгүй аж ахуйн нэгж байгууллагаар гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах хугацаатай албан шаардлагыг аймгийн БОАЖГ-т хүргүүлээд байна.

¹⁵ БОНХСайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны А-96/71 тушаалаар баталсан журам

¹⁶ БОНХСайд, Сангийн Сайдын 2013 оны 12 сарын 25-ны өдрийн А-368/302 тушаалаар баталсан.

БҮЛЭГ 3

Ойн менежмент төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж шалгаагүй, үр нөлөөг тооцоогүй байна.

“ойн менежментийн төлөвлөгөө” гэж тухайн засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх, эсхүл эзэмшлийн ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд чиглэсэн ойн аж ахуйн арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг цогц байдлаар, тодорхой үе шаттайгаар тусгаж төлөвлөсөн баримт бичгийг¹⁷ хэлнэ.

3.1.1. Аймгийн ойн менежментийн 2016-2020 оны төлөвлөгөөг батлуулаагүй байна.

Аймгийн Ойн менежментийн 2011-2015 оны төлөвлөгөөг БОАЖСайдын 2011 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А-156 дугаар тушаалаар батлуулж хэрэгжүүлжээ. Харин шинэ буюу 2016-2020 оны төлөвлөгөөг боловсруулсан хэдий ч БОНХСайдын тушаалаар батлуулаагүй байна. Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.27-д “...ойн менежмент төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар, тэдгээрийг боловсруулах заавар, журам батлах” гэж Байгаль орчны яамны хэрэгжүүлэх эрх үүргийг тодорхойлсон боловч аймгийн БОАЖГ-т энэ заалтын дагуу боловсруулсан заавар, журам ирээгүйгээс өмнөх буюу 2009 онд Ойн газрын даргын тушаал¹⁸-ын хавсралтаар баталсан Үлгэрчилсэн загварын дагуу боловсруулсан байна.

3.1.2. Ой бүхий сумын ойн менежментийн төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулаагүй байна.

Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.10-д аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхийг “ой бүхий сум, дүүргийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэнд хяналт тавих” гэж тодорхойлсон. Гэтэл Архангай аймгийн ой бүхий 16 сумын 2015-2017, 2015-2018 оны ойн менежментийн төлөвлөгөөг аймгийн БОАЖГ-ын дарга баталсан нь аймгийн Засаг даргын бүрэн эрхэд халдсан үйлдэл болжээ. Аймгийн БОАЖГ-ын дарга нь Ойн тухай хуулийн 17.3.9-д заасан буюу “ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөг л батлах, хэрэгжилтэнд хяналт тавих эрхтэй юм.

3.2.1. аймаг, сумын ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж, хэрэгжилтийн үр нөлөөг тооцоогүй байна.

Аймгийн Ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг гаргаж төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж байгаа боловч хэрэгжилтэнд хяналт шалгалт, хийж үнэлэлт дүгнэлт өгөөгүй байна. Тухайлбал: ойн менежмент төлөвлөгөөнд тусгасан талбайгаас хэдэн га талбайг ойжуулсан, нэн тэргүүний шаардлагатай талбайд хийсэн үү, үр дүн нь ямар байна вэ гэх мэтээр гүйцэтгэсэн ажлыг

¹⁷ Ойн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалт

¹⁸ Ойн газрын даргын 2009 оны 06 сарын 24-ний өдрийн 70 тушаал

төлөвлөгөөтэй харьцуулж үнэлээгүй, тухайн жилд хийсэн ажлаа тоочин бичсэн тайланг л гаргаж, хүргүүлж байна.

Цаашилбал ой бүхий сумаас ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргаж аймгийн БОАЖГ-т ирүүлдэггүй, төлөвлөгөөний хэрэгжилтэнд сум дундын ойн анги, БОАЖГ-аас хяналт шалгалт хийж, хэрэгжилтийг хангуулах талаар ямар ч арга хэмжээ аваагүй байна. Эндээс харвал аймаг, сумын Ойн менежмент төлөвлөгөө нь “ор нэр” төдий зүйл болж орон нутаг өөрийн гэсэн бодлого, төлөвлөгөөгүй зөвхөн тухайн жилд батлагдсан төсвийн хэмжээнээс хамаарч ойг нөхөн сэргээх, үржүүлэх ажлыг сүүлийн 3 жилд харилцан адилгүй хэмжээгээр гүйцэтгэж, үр дүн муутай хийж ирсэн байна.

_____ООО_____

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох баримт, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийлээ.

- Ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагааны зардлыг хуульд заасан хувь хэмжээгээр тооцож төлөвлөдөггүй, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан, ойн менежмент төлөвлөгөөнд тусгаагүй газарт ойжуулалт хийсэн зэргээр хууль, тогтоомжийг зөрчиж, батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй байна. Түүнчлэн сүүлийн 3 жилд хийсэн ойжуулалтын 63.3 хувь нь ургаагүй, шаардлага хангахгүй байгаа нь төсвийн 190.3 сая төгрөгийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан гэж үзэхэд хүргэж байна.
- Ойг нөхөн сэргээх, үржүүлэх талаар хууль, тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилт хангалтгүйгээс ойн мэргэжлийн байгууллагууд өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлбэл зохих ойжуулалтын **98.3** хувийг хийгээгүй, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ойжуулалтын **65.2** хувь нь шаардлага хангахгүй болсон зэргээс ойжуулах ажил үр дүнгүй болж үүний улмаас ойн сан нэмэгдээгүй байна. Энэ зөрчил цаашид ч үргэлжилсээр улсын ойн сан хохирсоор байхад хүрчээ.
- Ойн менежмент төлөвлөгөөг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаар хянуулж батлуулаагүй, хэрэгжилтийг хангуулах талаар арга хэмжээ аваагүй, гүйцэтгэлийг төлөвлөлттэй харьцуулан дүгнэлт хийж, үр дүн, үр нөлөөг тооцоогүй байгаа нь “Ойн менежментийн төлөвлөгөө ор нэр төдий зүйл болсныг харуулж байна.
- Орон нутагт ойн менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангуулах, үр дүн, үр нөлөөг тооцох, ойг нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагааг үр ашигтай, үр дүнтэй хэрэгжүүлэх, хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай болжээ.

ҮАГ-ЫН ХАРЪЯА АРХАНГАЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

ЗӨВЛӨМЖ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Ц. МӨНХНАСАН ТАНАА

1. Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.10 дахь заалтыг хэрэгжүүлж ой бүхий сумын “Ойн менежмент төлөвлөгөө”-г батлах, хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж дүнг аймгийн ИТХ-д хүргүүлэх
2. Орон нутгийн төсвөөс Ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагаанд зарцуулах зардлын хэмжээг ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын 85 хувиар тооцон төлөвлөж батлуулах
3. Ойд цэвэрлэгээ хийх үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, тэднийг дэмжих, урамшуулах талаар орон нутгийн бодлого шийдвэрт тусгаж, үйл ажиллагааг чиглүүлэн ажиллах талаар тодорхой арга хэмжээ авах

Энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлснээр ойн санг нөхөн сэргээх, ойжуулах талаар орон нутгийн бодлого, төлөвлөгөө тодорхой болж, хэрэгжилтийг хангуулснаар аймгийн хэмжээний ойн сан нэмэгдэх, байгалийн аясаар сэргэн ургах, нөхцлийг бүрдүүлэх, ойгоос олох орлого, ажлын байр нэмэгдэх зэрэг экологийн болон эдийн засаг, нийгмийн ач холбогдолтой үр дүнтэй ажил болох юм.

АЙМГИЙН БОАЖГ-ЫН ДАРГА Н. БАЯНМӨНХ ТАНАА

1. Аймгийн “ойн менежментийн төлөвлөгөө”-г шинэчлэн боловсруулж нэн даруй батлуулах, уг төлөвлөгөөнд ойжуулалт хийх газар, талбайг дэс дараатайгаар тусгах, хэрэгжилтийг хэзээ, хэнд хэрхэн тайлагнах, төлөвлөгөөний үр дүнг хэрхэн тооцох талаар тодорхой тусгаж өгөх
2. Ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тооцон, тайланг аймгийн Засаг даргад хүргүүлж байх
3. Ой бүхий сумын ойн менежмент төлөвлөгөөг хянаж, аймгийн Засаг даргаар батлуулах
4. Урьд оны ойжуулалтын ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн байгууллагуудтай улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр ойжуулалтын ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулахгүй байх
5. Ойгоос мод бэлтгэсэн аж ахуйн нэгж байгууллагаар тухайн жилд өөрийн хөрөнгөөр гүйцэтгэвэл зохих ойжуулалтын ажлыг заавал хийлгэж, хүлээн авах
6. Ойжуулалтын ажлыг хүлээн авсан гүйцэтгэлийн актыг иргэд олон нийтэд нээлттэй мэдээлэх
7. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр түүнчлэн өөрийн хөрөнгөөр ойжуулалт хийсэн, хийж буй талбайд технологийн болон үе шатны хяналтыг жилд 2-оос доошгүй удаа хийж баримтжуулан холбогдох арга хэмжээг авч ажиллах
8. Ойжуулалтын ажлын гэрээний биелэлтийг жил бүр дүгнэх, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч байх

Энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлснээр аймаг орон нутагт хийгдэх ойжуулалтын ажлын төлөвлөгөө тодорхой болж, уг ажлыг чанартай, үр ашигтай гүйцэтгүүлэх, үр дүнг тооцох, цаашид авах арга хэмжээг тодорхойлж хэрэгжүүлэх зэрэг үр дүнд хүрч аймгийн ойн сан нэмэгдэх боломжтой юм.

_____○●○_____

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ


**АРХАНГАЙ АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**
68130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас: 7033-3223, Факс: 7033-3223
E-mail: Arkhangai_arvy@mail.mn

2016.11.02 № 430

танил -ны № -т

Санал хүргүүлэх тухай

АРХАНГАЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

а/а Нарийнбасгагч.
Тогтоол. Санал.
сууцлаг. Дорж

Ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх ажлын гүйцэтгэлд хийсэн аудитын ажлын тайлангийн төсөлтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Ойжуулалт, байгалийн сэргэн ургалтанд туслах ажлын гүйцэтгэлийг шалгахдаа мэргэжлийн ойн инженерийг ажлын хэсэгт оруулж үнэлэлт дүгнэлт гаргуулах.

2. Ойжуулалт, байгалийн сэргэн ургалтанд туслах ажлын гүйцэтгэлтэй газар дээр нь танилцаж үнэлэлт дүгнэлт өгөхдөө таримал ургамлын ургалт жигдэрсэн үе болох 7 дугаар сарын сүүлээр хяналт мониторингийг явуулж байх.

Аймгийн 2016-2018 он хүртэлх ойн менежментийн төлөвлөгөөний төслийг боловсруулан БОАЖЯ-нд хянуулахаар төслийг хүргүүлсэн.

Цаашид ойн менежмент төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангуулан үр дүнг тооцон, ойн мэргэжлийн байгууллагуудтай экологийн хариуцлагийн гэрээ байгуулан гэрээний хэрэгжилтийг хангуулан ажиллахыг үүгээр хүргүүлж байна.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Н. БАЯНМӨНХ



АЛБАН ШААРДЛАГА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА АРХАНГАЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2016 оны 10 сарын 26 өдөр

Дугаар 01/00

ААГ-12016/02-ГА

Цэцэрлэг

АРХАНГАЙ АЙМГИЙН БОАЖГ-ЫН ДАРГА
Н. БАЯНМӨНХ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт заасан аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд "Ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн үр дүн"-д гүйцэтгэлийн аудит хийж байна. Энэ аудитын явцад 2014-2016 онд Архангай аймагт улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлсэн ойжуулалт, БСУТА-ын гүйцэтгэлийг газар дээр нь үзэж, жишиг талбайд тарьц суулгацын амьдралтыг тоолж шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Цэцэрлэг сумын Эхний хавтгай, Эхний булагт 40 га талбайд Ойд хангай ХХК 2015 онд улсын төсвийн 27.8 сая төгрөгөөр ойжуулсан талбайн тарьц суулгацын 52.3 хувь ургасан, хамгаалалт, хаяг, тэмдэгжүүлэлт, анхааруулах самбар хийгээгүй.
2. Хотонт сумын Өндөрсант багийн Модот толгойд 2015 онд "Ойд хангай" ХХК улсын төсвийн 13.9 сая төгрөгийн хөрөнгөөр 10 гад хийсэн ойжуулалтын тарьцын 10 хувь нь ургасан.
3. Хотонт сумын Орхон багийн Ар жаргалантад 10 гад 2014 онд орон нутгийн төсвийн 6.9 сая төгрөгөөр Цахир баян Уул ХХК-ий хийсэн ойжуулалтын тарьцын 30 хувь ургасан.
4. Өлзийт сумын Шандатад 25 гад Ойд Хангай ХХК 2015 онд орон нутгийн төсвийн 16.5 сая төгрөгөөр хийсэн ойжуулалтын тарьцын 40 хувь ургасан.
5. Хайрхан сумын Адуун зураад 20 га, Хэцүүгийн овоо 20 гад Олз мод ХХК-ний 2015 онд улсын төсвийн 27.6 сая төгрөгөөр гүйцэтгэсэн ойжуулалтын тарилт дутуу.
6. Батцэнгэл сумын Овгор улаанд 2015 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр Тэлээ таван хайрхан ХХК-ний гүйцэтгэсэн ойжуулалтын тарьц 40 орчим хувь ургалттай, хамгаалалт, хаяг, тэмдэгжүүлэлт, анхааруулах самбар хийгээгүй.
7. Өндөр-Улаан сумын Бэлхи багийн Гарчинд 20 гад Ойд хангай ХХК-ний 2016 онд орон нутгийн төсвийн 12.8 сая төгрөгөөр гэрээлж гүйцэтгэсэн ойжуулалтын тарьцын 50 хувь ургасан, хамгаалалт, хаяг, тэмдэгжүүлэлт, анхааруулах самбар хийгээгүй.
8. Эрдэнэмандал сумын Тээл багийн Өл хэмээх газар 50 гад Мөнхгэрэлмандал ХХК-ний 2016 онд орон нутгийн төсвийн 9.95 сая төгрөгөөр БСУТА хийсэн жишиг талбайн үрийн цухуйлт 40 хувь, хамгаалалт, хаяг, тэмдэгжүүлэлт, анхааруулах самбар хийгээгүй.
9. Цэцэрлэг сумын төвд зөвхөн хайс, хамгаалалтын ажил хийхэд 44.4 сая төгрөг зарцуулахаар гэрээ байгуулж, гүйцэтгүүлсэн нь ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн ажлыг орхигдуулсан буюу ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагааны зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Ойн тухай хуулийн 23.2.4-д "Өөрийн гүйцэтгэсэн ажлын үнэн зөвийг

хариуцаж, үйл ажиллагааныхаа талаар төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах", БОНХСайд, Сангийн Сайдын 2013 оны 03 сарын 29-ны өдрийн А-96/71 хамтарсан тушаалаар баталсан "Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам"-ын 4.7-д "Ойжуулсан талбайг 3 жил арчилж ургуулах, шаардлагатай үед нөхөн тарилт хийнэ", аймгийн БОАЖГ-ын дарга, ойжуулалтын ажил гүйцэтгэгч нартай байгуулсан гэрээний тусгай нөхцлийн нэмэлтийн "ж"-д "ойжуулсан талбайг 3 жил арчилж ургуулах, шаардлагатай үед нөхөн тарилтыг хийнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн Аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-д "...аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны 09 сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн Аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлагад өгөхөд баримтлах журам"-ын 4.1.3-д "Төсвийн хөрөнгийг үр ашиггүй ... зарцуулж Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн", 4.1.7-д "хууль, тогтоомж зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

1. Монгол Улсын БОНХСайд, Сангийн Сайдын 2013 оны 03 сарын 29-ны өдрийн А-96/71 хамтарсан тушаалаар баталсан "Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам"-ын 3.2.2-д "Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний биелэлтийг дүгнэж, төсвөөс олгох хөрөнгийг тооцож санхүүжүүлэх..." гэж заасныг хэрэгжүүлж 2014-2016 онд аймгийн БОАЖГ-тай гэрээ байгуулан ойжуулалт, БСУТА-ыг гүйцэтгэсэн "Ойд хангай" ХХК, "Олз мод" ХХК, "Цахир баян Уул" ХХК, "Мөнхгэрэлмандал" ХХК, "Тэлээ таван хайрхан" ХХК-аар дээрх журмын 4.7 дахь заалт ба гэрээний тусгай нөхцлийн нэмэлтийн "ж"-д заасан "ойжуулсан талбайг 3 жил арчилж ургуулах, шаардлагатай үед нөхөн тарилтыг хийнэ", гэрээний тусгай нөхцлийн 32-д заасан "Чанарын баталгаат хугацаа 3 жил байна" гэсэн үүргийн биелэлтийг хангуулж журам ба гэрээнд заасан шаардлагыг хангах нөхөн тарилтыг хийлгүүлэх, ойжуулсан талбайн хаяг, тэмдэгжүүлэлт, хамгаалалтын ажлыг гүйцэтгүүлж, комисс томилон хүлээн авах, нөхөн тарилт хийгээгүй болон хийсэн ажил нь шаардлага хангаагүй тохиолдолд гэрээний хэрэгжилтийг хангуулахаар эрх бүхий байгууллагад хандах арга хэмжээ авах
2. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд гүйцэтгэсэн ойжуулалт, ой нөхөн сэргээх, ногоон байгууламж нэмэгдүүлэх ажлын санхүүжилтийг тооцон олгох, гүйцэтгэлийг хүлээн авахдаа "Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам"-ын 4.5 ба 4.6-д заасан зарчмыг чанд баримтлах, гүйцэтгэлийг мөн журмын 4.9-д заасны дагуу хүлээн авч, нотлох баримтыг аймгийн Аудитын газарт ирүүлэх
3. Сумын төвийн ногоон байгууламж, нэмэгдүүлэх, цэцэрлэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг зориулалт бусаар захиран зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, Цэцэрлэг суманд 2016 онд төсвийн хөрөнгөөр барьсан хайсанд мод тарьж, цэцэрлэгжүүлэлт хийлгүүлэх, хүлээн авах ажлыг 2016 оны 11 сарын 10-ний дотор зохион байгуулах, цаашид энэ төрлийн зардлыг ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт бий болгох зориулалтын дагуу зарцуулах арга хэмжээг авах

Албан шаардлагад дурдсан зөрчлийг арилгаж биелэлтийг 2016 оны 11 сарын 15-ний дотор аймгийн Аудитын газарт ирүүлэхийг аймгийн БОАЖГ-ын дарга Н. Баянмөнх, тус газрын Ойн нэгжийн дарга А. Амарбаясгалан нарт даалгав.



АЛБАН ШААРДЛАГЫГ
Д. НЭРГҮЙБААТАР



¹ Терийн Аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д Терийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг терийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.